



20.18 оны 03 сарын 07-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 4 сарын 17-ны Мягмар гарагийн 14:00 цагт Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 3 сарын 27-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2018 оны 3 сарын 9-ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2018 оны 3 сарын 12 болон 3 сарын 27-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2018 оны 3 сарын 16-ны өдрийн дотор брокер диллерийн компаниудад хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралт, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр баталсугай:

Комиссын дарга:	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Н.Сүрэнрагчаа
Гишүүд:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	Захиргаа, хүний нөөцийн газрын захирал	Ч.Солонго



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.18 оны 03 сарын 04-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Зургаа. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Н.Сүрэнрагчаа-д даалгасугай.

Долоо. Саналын хуудсаар санал авах сүүлчийн өдрийг 2018 оны 4 сарын 12-ны өдрөөр тогтоож, саналын хуудсын агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ


Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН




Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 03 сарын 07-ний өдрийн хурлын
11-р тогтоолын 1 дүгээр хавсралт

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэн батлах
3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
4. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ,
ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Гүйцэтгэх ажлын утга	Эцсийн хугацаа	Хариуцах эзэн
А. ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ			
1	Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан илтгэл, холбогдох шийдвэрийн төсөл	III/9	Д.Гэрэлмаа М.Сэлэнгэ
2	Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэж, хэвлүүлж, тараах	III/16	М.Сэлэнгэ
Б. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ			
1	“Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх	III/9	М.Сэлэнгэ
2	Хурлын зар мэдээ гаргах, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх	III/12, III/27	М.Сэлэнгэ
3	Хурлын танхимын бэлтгэл, зохион байгуулалт, тоног төхөөрөмжөөр хангах, хурлын хэвийн явцыг хангах	IV/17	Ч.Солонго
4	Хурал дээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулах компанийн үйл ажиллагааны талаарх танилцуулга бэлдэх	IV/10	М.Сэлэнгэ
5	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх компанийн талаарх видео, үзүүлэн бэлдэх	IV/10	М.Бурмаа
6	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд гарсан дэвшилттэй талыг харуулсан загварын үзүүлэн бэлдэх	IV/10	Б.Болормаа
7	Саналын хуудсыг хэвлүүлэх	IV/6	М.Сэлэнгэ
8	Хурлын тэмдэглэл хөтлөх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангуулах	IV/13	Ч.Солонго

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2018 оны 03 сарын 04-ний өдрийн хурлын
11-р тогтоолын 3 дүгээр хавсралт

**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2018 оны 3 сарын 16-ны өдрөөс эхлэн 4 сарын 13-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ ирж танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл



Говь-ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын 2018 оны 08 сарын 04-ний өдрийн хурлын дүгээр хавсралт



“ГОВЬ” ХУВЬЦЛАЛТ КОМПАНИ
ХУВЬЦЛАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ
ХУУДАС

Говь-ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэлэлт хурал 2018 оны 4 сарын 17-ны өдрийн 14:00 цагт Говь-ХК-ийн өргөдөл “Мираж”-д эрх баригчид хуралдаанаа хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр төрөл жилийн
Эзэмшигч бүр хувьцааны тоо
Дансны дугаар Регистрийн дугаар

Батлах жуураар	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түгээгдсэн
----------------	------------	------------	------------

1. Компаний үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгээлтийг батлах
(Саналыг засгийн орхонд тооцно.)

Дүгээлтийг: Өөрийнхөө хувьцаагчид бүрэн
бүрэн амжилттай авчирсан ☐ төрөл ☐ жилийн ☐

2. Компаний дүрмэд оруулах өөрчлөлтийг батлах (Саналыг засгийн орхонд тооцно.)

Санал: Өөрчлөлтийг: оруулах ☐ төрөл ☐ жилийн ☐

3. ТУЗ-ийн гишүүд өөр дэвшигчдийг батлах (Саналыг засгийн орхонд тооцно.)

Санал: ТУЗ-ийн хуралд бүрэн амжилттай авчирсан ☐ төрөл ☐ жилийн ☐

Нэр дэвшигчид өгөх
кумулагт санхүүгийн тоо

1. Мэгэрийн БАЯР
2. Дамбын ГЭРЭЛМАА
3. Баянгол-ийн НАНДИН-ЭРДЭНЭ
4. Тасгийн КАМБЭ
5. Зууны ШАГДАРСҮРЭН

Санал: ТУЗ-ийн өөрийнхөө хувьцаагчид бүрэн амжилттай авчирсан ☐ төрөл ☐ жилийн ☐

1. Цагаачийн БААТАРСАЙХАН
2. Жалзасгаларын ОЮУНЧИМЭГ
3. Хуучин САВАДА
4. Дамбалын ХУЛАН

4. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшуулалыг шийдэх (Саналыг засгийн орхонд тооцно.)

Санал: Цалин урамшуулалыг хийхгүйг шийдэх ☐ төрөл ☐ жилийн ☐

2018 оны ...-р сарын ...-ны өдөр
Гарын үсэг

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Саналын хуудсыг дараах зааварын дагуу бөглөнө.

- Саналын энгийн аргаар тоолох асуудлын хувьцаагчид саналын хувьцаагчид зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
- Засварласан, баталсан, (✓)ээс өөр тэмдэгтэй хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал хураах бөгөөд хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох 5, өөрийн гишүүнийг сонгох 4 саналын эрх байна. Энэхүү саналын эрхээ хараат бус болон өөрийн нэг нэр дэвшигчид бүтлийг нь эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой.

2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, харилцаагч брокер дилерийн компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36434, Говь-ХК хамаар 2018 оны 4 сарын 13-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувицаа эзэмшигчид буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:
Овог нэр
Таныг:
Овог нэр
Утасны дугаар
Гарын үсэг



/Хэвлэл мэдээллийн эх/

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 4 сарын 17-ны өдрийн 14:00 цагт Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд болох тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2018 оны 3 сарын 27-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. ТУЗ-өөс компанийн 2017 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэн батлах
3. 2016 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
4. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай хэлэлцэн батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2018 оны 3 сарын 16-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах ТУЗ-ийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс өөрийн харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2018 оны 4 сарын 13-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга Н.Сүрэнрагчаа
Утас: 7013-9977(1002)
Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ
Утас: 7013-9977(1193), 9411-8277
И-мэйл: selenge.m@gobi.mn

Говь ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, "Говь" ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 04-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга:	Ч.Солонго – Захиргаа, хүний нөөцийн газрын захирал
Нарийн бичгийн дарга:	М.Болортуяа – Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Ц.Цэцэгбадам – Ахлах нягтлан бодогч
	З.Золжаргал – Сургалт, хөгжил идэвхжүүлэлтийн менежер
	П.Төгсжаргал - Мэдээлэл технологийн инженер

Хоёр. Тооллогын комисс (Ч.Солонго)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Саналын хуудсыг хайрцагаар авах;
6. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
7. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР





MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20¹⁸ оны ⁰³ сарын ⁰⁴-ны өдөр

Дугаар ¹⁶²

Улаанбаатар хот

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20...¹⁸ оны ...⁰³ сарын ...⁰⁴-ны өдөр

Дугаар ¹³...

Улаанбаатар хот

Редакцын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Редакцын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцсэний үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын редакцын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Комиссын дарга: Ц.Цасчихэр – Говь ХК-ийн хуулийн зөвлөх
Гишүүд: М.Сэлэнгэ – Говь ХК-ийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга

Хоёр. Редакцын комисс (Ц.Цасчихэр)-т даалгах нь:

1. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тусган найруулах;
2. Хурлаас гарах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдээлж батлуулах;

ТУЗ-ийн ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД:

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

З.ШАГДАРСҮРЭН

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

